

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр, Мягмар гараг**

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-3

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 4-6

---

*1. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023.01.30-ны өдрийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан боловсруулсан/* 4-6

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны  
03 дугаар сарын 28-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 57 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Бат-Амгалан, Ц.Сэргэлэн, Д.Цогтбаатар;  
Эмнэлгийн чөлөөтэй: Т.Аюурсайхан, С.Батболд, Б.Дэлгэрсайхан;  
Тасалсан: Д.Бат-Эрдэнэ, Д.Ганбат.

**Нэг.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023.01.30-ны өдрийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан боловсруулсан/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Б.Энх-Амгалан:** Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан техникийн саатал гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгов.

Хуралдаан 15 цаг 01 минутаас 15 цаг 22 минут хүртэл техникийн саатлын улмаас түр завсарлав.

**Б.Энх-Амгалан:** 1.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 1  
Бүгд: 10  
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 1  
Бүгд: 10  
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 1  
Бүгд: 10  
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Нээлттэй хуралдаан 12 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 15 цаг 27 минутад хаалттай горимд шилжив.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”  
танхим  
14 цаг 57 минут.

### **АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Энх-Амгалан:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Б.Энх-Амгалан ирсэн, Н.Алтанхуяг гишүүн ирсэн, Г.Амартүвшин гишүүн ирсэн, П.Анужин гишүүн ирсэн, Т.Аюурсайхан гишүүн өвчтэй, Э.Бат-Амгалан гишүүн гадаад томилолттой, Б.Баттөмөр гишүүн ирсэн, Х.Баделхан гишүүн ирсэн, С.Батболд гишүүн өвчтэй, Б.Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, Д.Бат-Эрдэнэ гишүүнийг хуралдаа ирэхийг сануулаарай. Х.Булгантуяа гишүүн ирсэн, Д.Ганбат гишүүнийг хуралдаа ирэхийг сануулаарай. Т.Доржханд гишүүн ирсэн, Дэлгэрсайхан гишүүн өвчтэй, Н.Наранбаатар гишүүн ирсэн, Ц.Сэргэлэн гишүүн гадаад томилолттой, Д.Цогтбаатар гишүүн гадаад томилолттой, Н.Энхболд гишүүн ирсэн. Ингээд ирц 52.6 хувьтай байгаа учраас хуралдааныг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай тухай хуулийн 11.6-д заасны дагуу нээж байна. Байнгын хуралдааны хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг

хамгаалах тухай хуулийг хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 1 сарын 30-ны өдрийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан боловсруулсан. Хоёр дахь асуудал Гадаад харилцааны яамны мэдээлэл сонсох хаалттай.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Алга байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4.1.3-д заасан горимын санал гэж Улсын Их Хурлын гишүүний зөвхөн хэлэлцэж байгаа асуудлаар санал гаргахыг дэс дараалал, хэлэлцэх дараалал, журмын талаар танилцууллаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023.01.30-ны**

*өдрийн хоригийг хүлээж авсантай  
холбогдуулан боловсруулсан/*

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88.8-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан бол хууль тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хүчингүй болгох шаардлагатай гэж үзвэл зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тогтоолын төслийг хэлэлцэн баталж болно гэж, 88.9-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан хууль тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах бол тухайн шийдвэрийн төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж, нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг төслийн талаар Засгийн газар холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй гэж заасан.

Ингээд хуулийн төсөлтэй холбоотойгоор хуулийн төслийг гишүүдэд тараасан байгаа. Ингээд Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсон тухай хуулийн төслүүдийг хэлэлцье.

Хуулийн төсөл төслүүд гишүүдэд тараагдсан учраас хуулийн төслүүдтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү?

Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна. Санал хураалт явуулъя. Олон нийтийн сүлжээнд хүний эрх хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Доржханд гишүүний картыг хийхгүй бол сая карт нь гарчихлаа. Тийм учраас Доржханд гишүүн санал гаргах уу? Доржханд гишүүний энэ нөгөө төхөөрөмжийг нь янзлаадхаач.

Энэ үдээс өмнөх хуралдаан дээр бас ийм техникийн санал гарсан юм байна. Тэгээд техникийн саатал гарсан учраас гишүүдийн ирц бүрдэхгүй, карт уншихгүй, дээр нь өгсөн санал хураагдахгүй байгаа учраас энэ Техникийн албанаас бидэнд хүсэлт тавьж байна. Энэ хурлыг дахин ирц бүрдүүлэх асуудал явуулж өгөөч гэж. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгох болгоод, тэгээд дахиж ирц бүрдүүлье. 5 минутын завсарлага авлаа.

Техникийн саатал гараад ямар ч байсан засаад дууссан байна. Эхний ээлжид ямар ч байсан бүртгэлийн санал хураалт явуулаадахъя гишүүдээ.

*Бүртгэлийн санал хураалт. Анужин гишүүний төхөөрөмж бас ажиллахгүй байх шиг байна энэ дээр нэг анхаараарай.*

*Одоо санал хураалт явуулъя. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 9, 10 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 90 хувийн саналаар санал дэмжигдлээ.*

*Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 9 гишүүн дэмжиж 90 хувийн саналаар санал дэмжигдлээ.*

*Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт, нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 80 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.*

*Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Татвар уу, ингээд дуусна тийм ээ. 90 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.*

*Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт*

*явуулъя. Санал хураалт. 70 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.*

*Олон нийтийн сүлжээнд хүний эрх хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа. Дээрх хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин танилцуулъя.*

16.26 цаг

*Дараагийн асуудалд оръё. Дараагийн асуудал Гадаад харилцааны яамны мэдээлэлтэй холбоотой асуудал байгаа. Асуудал нууцын журмаар орж ирсэн учраас хаалттай хэлэлцэнэ. Хуралдааныг хаалттай горимд шилжүүлъя. Ажлын хэсгийг урья.*

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА**